



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2017 оны 12 сарын 19 өдөр

Дугаар А/249

Улаанбаатар хот

Сургалт зохион байгуулах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/203 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын 4.7.6, 7.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “ЖАЙКА” ОУ-ын байгууллагатай хамтран зохион байгуулах “Эмнэлзүйн сургагч багш” бэлтгэх сургалтын удирдамж, хөтөлбөрийг нэгдүгээр, төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Сургалт зохион байгуулахад шаардагдах төсвийг Хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Д.Гантуяа/-д зөвшөөрсүгэй.

3. Сургалтыг удирдамжийн дагуу чанартай зохион байгуулахыг Эрүүл мэндийн ажилтны хөгжлийн алба /З.Наранбаатар/-д үүрэг болгосугай.


4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүү-үйлчилгээний алба /Л.Оюунчимэг/-д даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



Б.НАРАНТУЯА

Ерөнхий захирлын 2017 оны 12 сарын
19 өдрийн 4 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт
249



ЭМНЭЛЗҮЙН СУРГАГЧ БАГШ БЭЛТГЭХ СУРГАЛТЫН УДИРДАМЖ

Үндэслэл:

Сүүлийн жилүүдэд Монгол улсын Засгийн газар эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын тогтолцоог сайжруулахын тулд идэвхитэй арга хэмжээ авч эхэлсэн. Үүнтэй холбоотой Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллагаас "Анхан ба хоёр дахь шатлалын эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах нь" төслийг хэрэгжүүлж, дэмжлэг үзүүлэн ажиллаж байгаа билээ.

Анхан ба хоёр дахь шатлалын эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах төсөл нь Монгол Улс, Япон Улсын засгийн газар хоорондын гэрээнд үндэслэн 2015 оны 5 сараас эхэлж 5 жилийн хугацаанд хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна. Энэхүү төслийн үйл ажиллагаа нь голчлон эмч нарт чиглэсэн ба төгсөлтийн дараах сургалтын чанарыг сайжруулснаар анхан ба хоёр дахь шатлалын эмнэлэгт үзүүлж буй тусламж үйлчилгээ сайжирна гэж үзэж байна.

Төгсөлтийн дараах сургалтын чанарыг сайжруулахын тулд эмнэл зүйн сургагч багшийг чадавхижуулж, тоог нь нэмэгдүүлэх шаардлагатай байгаа билээ. "Эмнэлзүйн сургагч багш" нь сурган заах арга эзэмшсэн удирдагч багш байх ба Япон Улсад төгсөлтийн дараах эмнэлзүйн эхний 2 жилийн сургалт болон резидентийн сургалт явуулахад томоохон үүрэг хүлээн ажилладаг. Төслийн үйл ажиллагааны хүрээнд Япон улсад зохион байгуулагддаг "Эмнэл зүйн сургалт удирдагч багшийн сургалт" –ын хөтөлбөрийн дагуу Монгол Улсын нөхцөл байдалд тохируулж 3 өдрийн сургалтын хөтөлбөрийг боловсруулан гаргасан.

ЭМЯ, ЭМХТ болон Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага хамтран "Эмнэлзүйн сургагч багш бэлтгэх сургалт"-ыг зохион байгуулах нийт 23 "Чиглүүлэгч багш" бэлтгэн багшийн үнэмлэх болон Японы Анагаах Ухааны Боловсролын Нийгэмлэгийн гэрчилгээ олгосон. Бэлтгэгдэсэн чиглүүлэгч багш нар нь цаашид төслийн хугацаанд тус сургалтыг ЭМХТ-тэй хамтран зохион байгуулах юм.

Зорилго:

Эмнэлзүйн сургалт удирдахад шаардагдах сурган заах арга зүй эзэмшсэн "Чиглүүлэгч багш" бэлтгэх

Сургалт зохион байгуулах байгууллага:

- Эрүүл мэндийн яам
- Эрүүл мэндийн хөгжлийн төв

Сургалт зохион байгуулагдах хугацаа, байршил:

- 2017 оны 12 сарын 26-28-ний өдрүүд
- ЭМХТ-ийн хурлын танхим

Агуулгын багтаамж: 2 багц цаг**Зохион байгуулагчдын бүрэлдэхүүн:**

- ЭМХТ –ийн төлөөлөл мэргэжилтэн – 1
- Чиглүүлэгч багш – 5
- Төслийн ажилтан – 3

Сургалтын хэлбэр:

Workshop хэлбэрийн сургалтаар дамжуулан эмнэлзүйн сургалтын сургагч багшаар ажиллахад шаардлагатай мэдлэг, чадвар, хандлагыг эзэмшүүлнэ.

Эзэмших мэдлэг:

Монгол улсын эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын тогтолцооны бодит байдал, тулгарч буй асуудал, сайжруулах арга зам юу болох, шинэ залуу эмчийн хувьд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар нь ямар байх, зорилтоо биелүүлэхийн тулд сургалтын төлөвлөгөөг хэрхэн зөв зүйтэй боловсруулах, ач холбогдол сайтай сурган заах арга, лекцийн арга барил, сургалтын үнэлгээг хэрхэн хийх зэрэг мэдлэгтэй болно.

Эзэмших чадвар:

Чиглүүлэгч багшид шаардагдах сурган заах арга зүй, сургалтын зорилт, төлөвлөгөө боловсруулах арга, асуудалд дүн шинжилгээ хийх арга, үнэлгээ хийх чадварыг эзэмшинэ.

Эзэмших хандлага:

Сургагч багшийн хувьд шинэ залуу эмч нарт чин сэтгэлээсээ хандаж, боловсон хүчин бэлтгэх үйл ажиллагаагаар дамжуулан Монгол улсын эрүүл мэндийн тусламж үйлчлэгч дээшлүүлэх үйлсэд хувь нэмрээ оруулах хандлагыг төлөвшүүлнэ.

Сургалтын арга зүй:

- Лекц (PLS – plenary session буюу нэгдсэн хэлэлцүүлэг)
- Багаар ажиллах, багийн ажлын үр дүнг тайлагнах (SGD – small group discussion буюу багийн хэлэлцүүлэг)


**2017 оны 12 сарын 26-28-ний өдрүүдэд
зохион байгуулагдах TOT сургалтад багшлах боловсон хүчин:**

№	Овог Нэр	Албан байгууллага	Боловсролын зэрэг
1	О.Батгэрэл	Улсын гуравдугаар төв эмнэлгийн сургалт, Эрдэм шинжилгээ, сургалт, хамтын ажиллагаа хариуцсан орлогч дарга	Анагаах ухааны доктор,
2	Б.Солонго	АШУҮИС-ийн дотрын тэнхимийн багш	Анагаах ухааны доктор
3	У.Цэвэгмид	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Хүүхдийн зөвлөх поликлиникийн эрхлэгч	Анагаах ухааны доктор
4	Н.Оюунцэцэг	АШУҮИС-ийн багш	Анагаах ухааны доктор
5	С.Гамуу	Халдварт өвчин судлалын үндэсний төв, Халдвартын тасгийн эмч	Анагаах ухааны магистр
6	Р.Базаррагчаа	Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Мэдээгүйжүүлгийн тасгийн эмч	Анагаах ухааны магистр

TOT : Сургалтын хөтөлбөр / 1 дэх өдөр: 2017 оны 12 сарын 26 /

Цаг	Сэдэв	Тайлбар	Багш	Хугацаа (мин)
8:40-9:00	Зохион байгуулагчдын уулзалт			20
9:00-9:20	Бүртгэл /Сургалтын өмнөх асуумж бөглөх/			20
9:20-9:30	Нээлт	ЭМХТ-ийн ерөнхий захирал Б.Нарантуяа		10
9:30-9:50	1. Сургалт зохион байгуулагчдын танилцуулга 2. Сургалтын үндэслэл, зорилгын талаар тайлбарлах			20
9:50-10:10	"Workshop" гэж юу вэ?	Workshop-ын тодорхойлолт, аргачлалыг тайлбарлах	Нэгдсэн хэлэлцүүлэг	20
10:10-11:00	Чөлөөтэй уур амьсгал бүрдүүлэх хэсэг	"Миний амьдралд тохиолдсон хамгийн сэтгэл хөдөлгөсөн эсвэл дурсамжтай үйл явдал"	Нэгдсэн хэлэлцүүлэг	10
		-Миний амьдралын хамгийн их сэтгэлд хоногшсон эсвэл дурсгалтай үйл явдлыг зургаар илэрхийлэх -Зургаар илэрхийлж, харилцан бие биедээ зурсан зургаа тайлбарлах	Багийн хэлэлцүүлэг	40
11:00-11:10	*Цайны завсарлага*			10
11:10-11:40	Чөлөөтэй уур амьсгал бүрдүүлэх хэсэг	Зураг тус бүрийг танилцуулах (Баг тус бүр 10мин)	Нэгдсэн хэлэлцүүлэг	30
11:40-12:00	Резидент эмч гэж хэн бэ?	Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалт, резидент эмчийн эрх зүй		20
12:00-13:00	*Үдийн завсарлага*			60
13:00-13:20	Танилцуулга хичээл	KJ аргын танилцуулга (Kawakita Jiro method)	Нэгдсэн хэлэлцүүлэг	20
13:20-14:40	Монголд шинэ төгссөн эмчээс эмнэлзүйн ямар суурь ур чадварыг шаардах вэ?	Багийн гишүүд Монголын нийгэмд хэрэгцээтэй зайлшгүй шаардагдах эмнэлзүйн ур чадварын тухай KJ аргачлал ашиглан хэлэлцэж, гарсан дүгнэлтээ том цаасан дээр гаргаж үзүүлэх	Багийн хэлэлцүүлэг	80
14:40-14:50	*Цайны завсарлага*			10
14:50-15:50	Монголд шинэ төгссөн эмчээс эмнэлзүйн ямар суурь ур чадварыг шаардах вэ?	1) Илтгэл (10мин) + хэлэлцүүлэг (10мин) = 20мин × 3 баг	Нэгдсэн хэлэлцүүлэг /	60
15:50 -16:20	Сэдэв тодорхойлох	Баг тус бүр дээрх яригдсан асуудлаас нэгийг сонгон авна. Сонгож авсан асуудлаар төлөвлөгөө боловсруулахдаа дараах төлөвлөлтийг хийнэ. /Зорилго, зорилт, стратеги, үнэлгээ/	Нэгдсэн хэлэлцүүлэг	30
16:20-16:35	1 дэх өдрийн асуумж бөглөх			15
17:15-18:00	Зохион байгуулагчдын уулзалт			45
1 дэх өдрийн нийт цаг				8 цаг

Ерөнхий захирлын 2017 оны 12 сарын
19 өдрийн А/ дугаар тушаалын хоёрдугаар хавсралт
1249



**“ЭМНЭЛЗҮЙН СУРГАГЧ БАГШ БЭЛТГЭХ ”
СУРГАЛТАД ЗАРЦУУЛАГДАХ ТӨСӨВ**

3-н өдрийн сургалт

№	Хэрэглэгдэх зүйлс	Хэмжих нэгж	Тоо, хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Бичиг хэргийн зардал	1 хүн	24	2.000	48.000
2	Гэрчилгээ	1 хүн	24	1.000	24.000
3	Цайны зардал	1 хүн/өдөр	30*6	2.000	360.000
4	Хоолны зардал	1 хүн/өдөр	30*3	6.000	540.000
5	Багшийн цагийн хөлс /доктор/	хүн *цаг	4*24	20.000	1920.000
6	Багшийн цагийн хөлс /магистр/	хүн *цаг	2*24	10.000	480.000
Нийт зардал					3.372.000

Хянасан:

Д.Гантуяа /Ерөнхий нягтлан бодогч/

Боловсруулсан: О.Баярсайхан О.Баярсайхан /ЭМАХА-ны мэргэжилтэн/